



**ОРХОН АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 01 дугаар сарын 15

Дугаар 03/01

Жаргалант сум

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Ажлын албаны бүтэц, орон тоог  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5, 22 дугаар зүйлийн 22.1.6, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны бүтэц, орон тоог хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Ажлын албаны бүтэц, орон тоо шинэчлэгдсэнтэй холбогдуулан хууль, журмын дагуу хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэшил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ц.Ганбаяр)-т даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Ээлжит VII хуралдааны 08 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Ш.БИЛГҮҮНБААТАР



6125010000

2

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны  
01 дүгээр сарын 15-ны өдрийн Ээлжит бус  
I хуралдааны 03/01 тогтоолын хавсралт

Сумын ИТХ-ын Ажлын албаны бүтэц, орон тоо

№	Албан тушаал	Төрийн албаны ангилал, зэрэглэл	Нэгж
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	УТ	1
2	ИТХ-ын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга	ТЗ-5	1
3	Хурлын Ажлын албаны Багийн иргэдийн Нийтийн Хурал, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн	ТЗ-9	1
4	Хурлын Ажлын албаны хэвлэлийн төлөөлөгч, олон нийттэй харилцах ажилтан	ТҮ-7	1
5	Хурлын Ажлын албаны нярав-жолооч	ТҮ-4	1
6	Хурлын Ажлын албаны нягтлан бодогч	ТҮМ-6	0,5

